



Залуучууд, насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих нээлттэй, зайны сургалт

Оршил

КОВИД-19-ийн дэгдэлтээс үүдэн дэлхий даяар сургуулиуд хаагдсанаар боловсролын яамд сургалтын тасралтгүй байдлыг хангах, сургууль, боловсролын байгууллагуудыг онлайн болон зайн сургалтын хэлбэрүүдийг судалж, ашиглахад нь дэмжлэг үзүүлж эхэлсэн. Насанд хүрэгчдийн сургалтын төв, албан бус боловсролын ихэнх байгууллагуудын танхимд суурилсан сургалтыг түр зогсоосны улмаас үр чадвар багатай насанд хүрэгчид, эмэгтэйчүүд, сургуулиас гадуурх залуус, шилжин ирэгсэд, дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг тусламж нэн шаардлагатай, албан ёсны сургуулийн тогтолцооноос гадуурх суралцагчид харамсалтай нь их хэмжээний хохирлыг амссан.

Өнөөгийн цар тахал нь амьдралын бүхий л давхаргын хүмүүсийг энэхүү хямралаас үүдэлтэй тодорхой бус байдлыг даван туулахад шинэ мэдлэг, чадварыг хөгжүүлэхийг шаардаж байна.

Эдгээр шинээр гарч ирж буй сургалтын хэрэгцээ шаардлагад эрүүл мэндийн суурь мэдлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол, гэрээр суралцаж буй хүүхдэд эцэг эхийн зүгээс үзүүлэх халамж, цар тахлын улмаас гарсан ажлын байрны алдагдлыг нөхөх мэргэжлийн хөгжил зэрэг орно. Иймээс нээлттэй онлайн хичээл (MOOCs)-ийн эрэлт хэрэгцээ огцом нэмэгдэж, 3, 4 дүгээр сарын хооронд зарим хичээлийн хамрагдалт өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулахад [607 хувиар өссөн](#) байгаа бөгөөд хамгийн их эрэлттэй нь нийгмийн эрүүл мэнд, урлаг, хувь хүний хөгжлийн хичээлүүд байна. Үүний зэрэгцээ албан бус боловсрол, насанд хүрэгчдийн суралцахуйн тасралтгүй байдлыг хангах нээлттэй, зайны сургалт (ODL) зэрэг өөр хувилбаруудыг судлах эрэлт хэрэгцээнд суурилсан эерэг чиг хандлагууд бий болж байна. Иймээс ЮНЕСКО-ийн онцлох асуудлын энэхүү

дугаарт [ЮНЕСКО-ийн зайн сургалтын стратегийн](#) талаарх онцлох сэдэвт тодорхойлсон албан боловсролын тогтолцооны гадна суралцдаг залуус¹ болон насанд хүрэгчдэд зориулсан нээлттэй зайн сургалтыг онлайн болон офлайн хэлбэрээр ашиглах боломж, бас сорилтуудын талаар өгүүлнэ. Гол асуудлуудыг шинжилж, төр, хувийн хэвшлийн салбарын тохиолдлуудыг танилцуулсны дараа цар тахлын болон түүний дараах үед залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан тэгш хамруулсан насан туршийн суралцахуйг дэмжих бодлогын оролцооны үндсэн санааг өгүүлэх болно.

Сэдэв болон холбогдох асуудлуудыг тодорхойлох

Нээлттэй болон зайны боловсрол нь албан боловсролын тогтолцоонд хамрагдаж чадаагүй залуучууд, насанд хүрэгчдийн сургалтын тасралтгүй байдлыг хангах, тахал өвчний улмаас бий болсон сургалтын олон төрлийн хэрэгцээ шаардлагыг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Сургалтын тасралтгүй байдлыг хангах нь албан боловсролын тогтолцоонд хамрагдаагүй хүмүүсийн цар тахлын дараах аж амьдралыг сайжруулахад тус дэм болно. Гэхдээ залуучууд, насанд хүрэгчдийн сургалтад нээлттэй, зайны боловсролыг түлхүү ашиглахын тулд дараах үндсэн асуудлуудыг авч үзэх шаардлагатай. Үүнд:

Интернэт, дижитал төхөөрөмжид нэвтрэх боломж хязгаарлагдмал хэвээр байна. 2019 онд дэлхийн нийт хүн амын нэлээд хэсэг буюу [46.4% интернэт ашиглах боломжгүй байсан](#) бөгөөд [үүний ихэнх нь бүүрай хөгжилтэй орны оршин суугчид байв](#). Дэлхийн бүх бүс нутагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү интернет ашигладаг. Түүнчлэн, интернетийн хүртээмжтэй холбоотой [жендэрийн ялгаа](#) нь олон бүс нутагт, ялангуяа хөгжиж буй орнуудад улам бүр нэмэгдэж байна. Жишээлбэл, Олон улсын цахилгаан холбооны байгууллагын мэдээлснээр 2019 онд дэлхий дахинд [интернет ашиглаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 48 байсан](#) бол эрэгтэйчүүд 58 хувьтай байсан. Энэхүү цар тахлаас үүдэлтэй хязгаарлалтын үед албан боловсролын тогтолцоонд хамрагдаагүй, ялангуяа цөөн тооны төхөөрөмжтэй айл өрхийн залуучууд, насанд хүрэгчдийг онлайн сургалтад хандуулах анхаарал багасаж, сургуулийн сурагчдыг цахим сургалтад илүү ач холбогдол өгч байгаа нь ажиглагдаж байна. Цар тахлын хариу арга хэмжээ болгон алсын зайн сургалтыг яаран нэвтрүүлсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохирсон төхөөрөмжийн дутагдалтай байсныг мэдээлсэн. Ийм болон бусад олон шалтгаанаас үүдэлтэй интернет, дижитал хэвлэл [мэдээллийн хэрэгслийн хүртээмжгүй байдал](#) нь ялангуяа ур чадвар сул, бага орлоготой эмзэг бүлгийн залуучууд, насанд хүрсэн суралцагчдын нээлттэй, зайн сургалтын хэрэгцээ шаардлагыг хангахад гол бэрхшээл тулгарч байна.

Бичиг үсгийн боловсрол тааруу, ур чадвар муутай залуучууд, насанд хүрэгчид үргэлжлүүлэн суралцах боломжийг эрэлхийлэх нь бага байдаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ([ЭЗХАХБ](#))-аас хийсэн Насанд хүрэгчдийн ур чадварыг хөгжүүлэх судалгаа (НХУЧХС)-аар ур чадвар багатай насанд хүрэгчид өндөр ур чадвар бүхий насанд хүрэгчидтэй харьцуулахад сургалтын шинэ хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх, суралцах шинэ боломжуудыг эрэлхийлэх магадлал нь харьцангуй бага байдаг (харьцаа нь 11.6 хувь болон 35.5 хувь). [Энэ нь жендэрийн хувьд их ялгаатай](#) ба бичиг үсгийн суурь боловсрол багатай насанд хүрэгчдийн гуравны хоёр нь эмэгтэйчүүд байгаагаас харагдаж байгаа бөгөөд энэ тоо сүүлийн 10 жилийн турш огт өөрчлөгдөөгүй байна. Түүнээс гадна насанд хүрэгчдийн сургалт, боловсролын хөтөлбөр (ALE)-т оролцох оролцоо бага байдаг бөгөөд бичиг үсгийн боловсрол багатай насанд хүрэгчид бие дааж суралцахад зориулсан НЗС-ын материалыг ашиглан сурахыг бэрхшээлтэй хэмээн үздэг байж болох юм.

¹ НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь “залуучууд”, “залуу хүмүүс” гэсэн нэр томъёог 15-аас 24 хүртэлх насны хүмүүст зориулан ашигладаг бөгөөд гишүүн орнууд болон бусад байгууллагууд өөр өөр тодорхойлолтыг ашигладаг болохыг хүндэтгэн үздэг. Энэхүү баримт бичгийн хүрээнд НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар энэхүү тодорхойлолтыг ашиглана. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.un.org/esa/socdev/documents/youth/fact-sheets/youth-definition.pdf> баримт бичгээс харна уу.

Энэ нь 2018 оны [ЭЗХАХБ](#)-ын Олон улсын оюутны үнэлгээний үр дүнтэй нийцэж байгаа юм. Дижиталчлалыг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч суурь үр чадвар багатай залуучууд дижитал мэдээллийг олон янзын хэлбэрээр танилцуулах үйл явцыг хэцүү хэмээн үзэж байсан. Залуучууд, насанд хүрэгчдэд суурь мэдлэгийг олгох нь ойрын харилцаа холбоо, хувь хүн тус бүрт зориулсан хариулт, нүүр тулсан багшийн зөвлөгөөг шаарддаг тул нээлттэй, зайны сургалтын ашиглалт яагаад бага байгаа талаар илүү нарийн судлах шаардлагатай юм.

Насанд хүрсэн суралцагчдын онлайнээр суралцахад шаардлагатай дижитал үр чадвар дутмаг байдаг. [Европт насанд хүрэгчдийн 43 хувь нь дижитал суурь мэдлэг байхгүй](#). Дижитал үр чадварын дутагдлыг нээлттэй, [зайн сургалтад оролцоход саад болж буй хүчин](#) зүйлсийн нэг гэж тооцсон. Боловсрол, нийгэм, эрүүл мэндийн халамж зэрэг олон чухал үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн өнөөгийн цар тахлын үед дижитал үр чадварын дутмаг байдал [ахмад настан, эмэгтэйчүүдийн дунд илүү их байгаа нь ажиглагдсан](#). [Дижитал суурь мэдээллийн ялгааг яаралтай арилгах](#) нь эрүүл мэнд, Засгийн газрын арга хэмжээний талаарх чухал мэдээллийг хүлээн авах боломжийг насанд хүрэгчдэд бий болгоод зогсохгүй, буруу ташаа, “хуурамч мэдээ”-тэй тэмцэхэд чухал ач холбогдолтой юм.

Албан бус боловсрол, насанд хүрэгчдийн сургалтад зориулсан дижитал агуулга хязгаарлагдмал байна. Залуучууд болон насанд хүрэгчдийн сургалтын дижитал агуулга хязгаарлагдмал байгааг илтгэх хэд хэдэн асуудал бий. Нэгдүгээрт, залуучууд болон насанд хүрэгчдийн албан бус боловсролын дэд салбарын оролцогч талуудын хоорондын зохицуулалтын механизм сул, бодлого хомс байсан нь шинээр гарч ирж буй суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээ авахад бэрхшээлийг бий болгож, холбогдох дижитал агуулгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нөөцийг хуваарилахад хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Хоёрдугаарт, зарим үр чадварын хөгжил нь практик сургалт, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж дээр ажиллах дадлага ажлыг шаарддаг бөгөөд энэ нь зайны сургалтын арга барилтай нийцдэггүй. Гуравдугаарт, одоо байгаа дийлэнх дижитал эх үүсвэрүүд нь цөөн хэдэн хэл дээр боловсруулагдсан бөгөөд хөгжингүй орнуудын нөхцөл байдалд илүү нийцдэг тул хэл, соёлын талаас нь авч үзвэл дэлхийн улс орнуудын бүх хэрэглэгчид шүүд хэрэглэх боломжгүй, мөн технологийн хувьд хөгжиж буй орнуудын суралцагчдын хэрэгцээ шаардлагад тэр бүр нийцэхгүй байна.

Нээлттэй, зайны сургалтын гэрчилгээ, баримт бичгийг тэр бүр хүлээн зөвшөөрч, баталгаажуулдаггүй. Нээлттэй, зайн сургалтаар дамжуулан олж авсан мэдлэг, үр чадварыг тэр бүр хүлээн зөвшөөрдөггүй. Энэ нь ихэнх оронд ийм сургалтын хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх системийн хөгжил хангалтгүй байгаатай холбоотой юм. Түүгээр ч барахгүй нээлттэй онлайн хичээлийг баталгаажуулахад төлбөр шаарддаг тул үүнийг зарим үед баян, ядуугийн хоорондын зөрүүг улам бүр нэмэгдүүлдэг “боловсролын технологийн төгс бус шийдэл” гэж нэрлэх тохиолдол ч бий.

Зарим сурган хүмүүжүүлэгчдийн суралцахуйн шинэ арга барилыг нэвтрүүлэх чадвар дутмаг байдаг. Ялангуяа дижитал шийдэлтэй сургалтын шинэ арга барил руу хурдан шилжихэд насанд хүрэгчдийн багш нарыг дэмжихийн ач холбогдлыг ихэвчлэн үл тоомсорлодог. Дижитал шийдэл эсвэл холимог сургалтын шийдлийн уян хатан байдал, дасан зохицох чадвар болон бусад давуу талыг насанд хүрэгчдийн багш, сургагч багш нарыг зайнаас хэрхэн заах талын сургалтад зохих ёсоор хамруулах замаар бүрэн хүргэх боломжтой юм. Жишээлбэл, цахим хичээлийн хувьд сургагч багш нар сургалтын арга барил, дижитал агуулга, алсын зайн үнэлгээ, хичээл төлөвлөлтийн талаар болон хэрэгцээнд суурилсан энгийн болон өндөр технологийн шийдлүүдийг хослуулах талаар мэдээлэлтэй шийдвэрүүдийг гаргах шаардлагатай байдаг.

Өмнөх туршлага, өнөөгийн хямралаас олж авсан сургамж

Хэдийгээр КОВИД-19 цар тахал шинэ сорилтыг дагуулдаг ч түүний эсрэг хариу арга хэмжээ нь удаан хугацааны туршид байсан бүтцийн болон чадамжийн асуудалд анхаарлыг хандуулж байна. Өнгөрсөн үеэс болон одоогийн хямралаас ирээдүйд хэрэгтэй олон сургамжуудыг авсан бөгөөд эдгээр нь одоогийн нээлттэй, зайн сургалтын стратегиудад нөлөөлсөн. Энэ хэсэгт зарим нэгэн зайн сургалтын санаачлагуудыг онцлон авч үзлээ.

Олон янзын сувгаар дамжуулан мэдээлэл түгээх, сургалт явуулах нь үр чадвар муутай, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн суралцагсдыг дэмжихэд үр дүнтэй гэдэг нь батлагдсан.

- [Того улсад](#) насанд хүрэгчдийн боловсролын төвийн сургагч багш нар КОВИД-19-ийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх кампанит ажлыг үндэсний хэл дээр хаалганаас хаалганд хүргэх ажлыг хийсэн.
- БНСУ-ын зүүн хэсгийн [Намвон](#) хотын насан туршийн сургалтын төвөөс суралцагч нэг бүртэй утсаар холбогдож тус төвийн үйл ажиллагаа эргэн сэргэх хүртэл цахим сургалтад хамрагдахыг уриалж сургууль завсардсан суралцагсдад хоёр дахь боломж олгох боловсролын хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж ажилласан байна.
- Үүний нэгэн адил Европын насанд хүрэгчдийн сургалтын цахим платформаас Ирланд улсад Засгийн газрын маягт бөглөх, хүүхдүүдийн даалгаврыг хийлгэхэд туслах зэргээр насанд хүрэгчдийн өдөр тутмын хэрэгцээ шаардлагад дэмжлэг үзүүлэх зорилгоор [үнэ төлбөргүй сургалтын үйлчилгээг утсаар үзүүлдэг болсон](#).

Гар утасны технологи нь гадуурхагдсан өсвөр насны залуучууд болон насанд хүрсэн суралцагчдад хүрэх таатай боломжийг бий болгодог. Үүнд:

- Интернетэд нэвтрэх боломж хэдийгээр тэгш бус байгаа боловч гар утас (гар утасны сүлжээ) - ны хэрэглээ илүү өргөн тархсан байгаа бөгөөд 2019 оны байдлаар дэлхий даяар утсаар холбогдох боломж 108 хувь (буурай хөгжилтэй орнуудад 74.9 хувь)-тай байна. [ЮНЕСКО-ийн Гар утсыг ашиглан суралцахад баримтлах бодлогын удирдамжид](#) гар утасны технологийг ашиглах 13 өвөрмөц ашиг тусыг нэрлэсэн бөгөөд үүнд сургалтын тасралтгүй байдлыг хангах асуудал багтсан.
- [ЮНЕСКО-ийн өөр нэг судалгаагаар](#) хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүдийн унших болон бичиг үсгийн боловсролыг дэмжихэд гар утасны сургалт үр нөлөөтэй болохыг харуулсан байна. Мөн [гар утсыг хоол, хувцаснаас бараг илүү ач холбогдолтой](#) гэж [дүрвэгсэд үзсэн байна](#).
- Бангладеш улсад ЮНЕСКО-ийн Насан туршийн боловсролын хүрээлэн, Майкрософт компанитай хамтран 2015-2018 он хүртэл [Гар утсаар дамжуулан бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх](#) төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд бичиг үсгийн боловсролын материал, мэргэжлийн сургалтын агуулгыг үндэсний хэл дээр нь хадгалах санг байгуулж, суралцагсад болон багш нарын санах ойн картанд байршуулснаар дараа нь төвөөс зааварчилгаатай гэрээр суралцах хувийн төхөөрөмж ашиглах боломжийг олгосон.
- АНУ-аас эхлээд Чили, Гана, Кени, Нигери зэрэг орнуудад тархсан [Cell-Ed](#) нь унших, бичих, ярих, тоо бодох, ажлын болон нийгмийн үр чадвар зэрэг чухал үр чадваруудыг насанд хүрэгчдэд заахад зориулагдсан шагнал олгогдсон, гар утасны сургалтын хөтөлбөр юм. Үүнийг интернет холболт байхгүй газарт, үнэтэй дата багц худалдаж авахгүйгээр ямар ч төрлийн гар утас (үндсэн загвар эсвэл ухаалаг гар утас), таблет эсвэл компьютерт ашиглаж болох юм.

Энгийн технологи эсвэл технологийн бус шийдэл нь суралцахуйн дижитал хуваагдлын нөлөөллийг бууруулах боломжтой.

- Хэвлэмэл материал болон [телевиз](#) , [радио](#)г хослуулан ашиглаж буй офлайн зайн сургалтууд залуучууд, насанд хүрэгчдийн суурь мэдлэг, тоо бодох чадварыг сайжруулж байгаа нь баримтаар нотлогдсон.
- Филиппин улсын сургалтын системийн хувилбар нь тогтолцооны гадна орхигдсон залуучуудад зориулсан суралцах олон аргуудыг хослуулах зорилготой. Тухайлбал, бичиг үсгийн суурь мэдлэг олгох хөтөлбөр нь мэдлэг багатай хүмүүст чиглэсэн бөгөөд радио,

компьютерт суурилсан заавар, бие даан суралцах, ТВ зааварчилгаа зэргийг багтаасан байдаг. Хичээлийн материалд хэвлэмэл материал, дижитал модулиуд, радио, телевизийн агуулга зэргийг хамруулсан.

- Афганистаны зарим бүс нутагт бичиг үсгийн хичээлийг орон нутгийн телевизүүдтэй хамтран боловсруулж, улсын [Боловсролын төлөвлөгөөний](#) нэг хувилбар болгон үндэсний хэмжээнд ТВ-ээр түгээдэг.

Бичил сургалт нь КОВИД-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээ гэх мэт яаралтай хэрэгцээг хангах боломжтой.

- Тайланд улсын [Сухотай Тамматхират нээлттэй их сургуулийн Харилцаа холбоо, мэдлэгийн менежментийн](#) хөгжлийн судалгааны төвөөс үндэстний цөөнх, тариаланч, хөдөөгийн эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийн хүмүүст зориулан эрэлт хэрэгцээнд суурилсан бичил онлайн сургалтыг боловсруулж зохион байгуулж байна. Цар тахалтай холбогдуулан тус судалгааны төв нь таксины жолооч нарт зориулан маск өмсөхөөс татгалздаг гадаадын иргэдтэй харилцах боломжийг олгох богино хэмжээний видео хичээлийг сайн дурын үндсэн дээр хийсэн.
- Европын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналтын төв нь КОВИД-19-ийн эсрэг эмийн бус арга хэмжээний талаар [бичил сургалтын олон ажлыг](#) эхлүүлсэн. Энэхүү ажлын үндсэн зорилго нь дэгдэлтийн нөлөөллийг бууруулах явдал бөгөөд тус сургалт нь бүх хүмүүст нээлттэй.
- Бенин улс [Доктор КОВИД ТВ](#) нэртэй вирусын тархалтыг зогсоход чиглэсэн богино хэмжээний ТВ цувралыг боловсруулсан.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэнийг ч орхигдуулахгүй байхад анхаарна.

- [Бүгд Найрамдах Солонгос Улсын](#) Боловсролын яам, Мэдээлэл технологийн яам, хувийн хэвшлийн цахилгаан холбооны гол компаниас хамтран бага орлоготой гэр бүлүүдийг үнэ төлбөргүй дата, төхөөрөмжөөр хангах чиглэлд ажиллаж, тэдэнд нээлттэй, зайн сургалтад оролцох боломжийг бий болгосон.
- Герман улсын Насанд хүрэгчдийн боловсролын холбоо нь [насанд хүрэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг](#) 2020 оны 3-р сараас эхлэн зогсоосон бөгөөд 2020 оны 4-р сард тус улсын Шилжилт хөдөлгөөн, дүрвэгсдийн газар нь дүрвэгсэд/цагаачдын интеграц болон залуучууд, насанд хүрэгчдийн хэлний бэлтгэлд зориулсан нээлттэй, зайны цахим сургалтыг дэмжих талаар мэдээлсний дараагаар шинэ суралцагсдын тоо огцом өсөж [150,000](#)-д хүрсэн байна. Герман улсын Насанд хүрэгчдийн боловсролын холбооны сургалтын порталаар дамжуулан түгээсэн үндэсний коллежуудаас олгосон үнэ төлбөргүй сургалтад суралцагчдын тоо мөн адил огцом өсчээ.

Албан бус сургалтыг хүлээн зөвшөөрч, гэрчилгээ олгох ажлыг шинэ арга замуудыг ашиглан хэрэгжүүлж болно.

- Уламжлалт бус сургалтыг хүлээн зөвшөөрч баталгаажуулахад бодлогын томоохон шинэчлэл шаарддаг боловч насан туршийн сургалтыг дэмжигчид програм хангамжийн инженерүүдтэй хамтран блокчейн технологийг ашиглан зарим цахим нээлттэй сургалтад хичээл болон кредитийн тооцоог нууцлалтайгаар баталгаажуулах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.
- Дижитал сургалтын баталгаат арга барилтай, магадлан итгэмжлэгдсэн үйлчилгээ үзүүлэгчдийн олон түншлэлт “ [Хилийн чанадад суралцах](#) ” хөтөлбөр нь Уганда дахь дүрвэгсдийн лагерийн суралцагсдад зориулж итгэмжлэлийн баталгаажуулалтыг бий болгон онлайн сургалтын дүнгээ мөшгөн, цуглуулахад тусалдаг.

Бодлого, хөтөлбөр зохицуулалтыг төлөвлөхтэй холбоотой гол санаа, практик зөвлөмж

Өнөөгийн болон өнгөрсөн хямралаас авсан сургамжуудад үндэслэн насанд хүрэгчдийн албан бус боловсролын тасралтгүй байдлыг хангах, нээлттэй, зайны сургалтыг ашиглахаар төлөвлөж буй Засгийн газар, боловсролын үйлчилгээ эрхлэгчдэд дараах зөвлөгөөг өгч байна.

Цар тахлын үед авах яаралтай арга хэмжээ:

Оролцоог хамгийн өргөн хүрээнд хангахын тулд сургалтад ашиглах хэвлэл мэдээллийн төрөл бүрийн суваг, хэрэгслүүдийг судлаж ашиглах.

- Утас, хэвлэмэл материал, текст мессеж, радио, телевиз, нарийн зурвасын багтаамж багатай нийгмийн мэдээллийн хэрэгсэл, богино хэмжээний бичил сургалтыг үр чадвар багатай, интернетэд нэвтрэх боломж хязгаарлагдмал байгаа суралцагчдын оролцоог нэмэгдүүлэхэд ашиглаж болно.
- [Судалгаагаар](#) график ихтэй, аудиод суурилсан интерфэйс нь бичиг үсгийн мэдлэг багатай залуучууд, насанд хүрэгчдэд хамгийн их үр өгөөжтэй байгааг харуулсан.
- Оюутнууд одоо байгаа [зурвасын өргөнийг оновчтой болгох хэрэгслээр](#) дамжуулан 2G эсвэл 3G-г ашиглах боломжтой. [Лобанд](#) зэрэг вэбэд суурилсан үнэгүй үйлчилгээгээр дамжуулан аливаа цахим хуудсыг зөвхөн текст хэлбэрт хувиргах замаар түүний хэмжээг эрс багасгах боломжтой.
- [Боловсролын хөгжлийн төвийн](#) интерактив радио [сургалтын хөтөлбөрийн каталог](#), [ЮНЕСКО-ийн онлайн болон офлайн сургалтын](#) нөөцийн жагсаалт нь ашигтай арга хэрэгсэл байж болно.

Цаг алдалгүй хариу арга хэмжээ авах үйл явцыг хурдасгахын тулд одоо байгаа нөөцийг ашиглах, нөөцийн жагсаалтыг бий болгох

- Шинэ материал бий болгохын оронд байгаа нөөцөө шалгаж, эмхэтгэх нь ихээхэн цаг хугацаа, зардлыг хэмнэж, сургалтын тасалдалд яаралтай хариу арга хэмжээ авахад тусална. Радио, телевизийн хөтөлбөрийн зорилгыг өөрчилж нэн шаардлагатай хэрэгцээнд ашиглах боломжтой. Орон нутгийн эрх бүхий байгууллагууд одоо байгаа онлайн сургалтуудыг тогтоохын тулд орон нутгийн их, дээд сургууль, дээд боловсролын байгууллагуудтай түншлэлийг байгуулж болно.
- Богино хэмжээний (таван минутаас доош үргэлжлэх) аудио, видео бичлэгүүдийг сонгон хялбархан ашиглах боломжтой бөгөөд үүнийг багш нар өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлэн хэрэглэж болно.

Санхүүгийн тусламж авахын тулд танхимаар суралцагч байх шаардлагыг хөнгөвчлөх

- Насанд хүрсэн суралцагчид, тэдэнд үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан санхүүгийн тусламж нь сургалтын бусад хэлбэрээс илүүтэйгээр уламжлалт буюу танхимаар суралцагчдад олгогдож байна. КОВИД-19-ийн дэгдэлтээс үүдэн хөдөлгөөн хязгаарлагдаж, эдийн засгийн хямрал үүссэн тохиолдолд Засгийн газрууд хичээлийг зайн сургалтын хэлбэрт шилжүүлэх зохицуулалтыг хийж, бие даасан онлайн суралцахуйд зориулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах хэрэгтэй.

Насанд хүрэгчдийн боловсрол олгогчдод багшлахуйн шинэ хэлбэрийг нэвтрүүлэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх

- Насанд хүрэгчдийн боловсрол олгогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг үл тоомсорлох байдал сургуулийн багш нартай харьцуулахад илүү байдаг тул тэдний дижитал болон багшлах чадвар хангалтгүй байдаг. Тиймээс онлайн арга хэрэгслийг ашиглах, зайны сургалтад зориулсан заах, сургах үйл ажиллагааг зохион байгуулахад зориулсан чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнүүд нэн шаардлагатай.
- Мэргэжлийн хөгжлийн арга хэрэгсэл, хэрэгслийн багцуудыг насанд хүрэгчдийн сургалтын багш нар нээлттэй ашиглах боломжтой. Үүнд [Суралцахуйн хамтын нөхөрлөлөөс гаргасан Боловсрол олгогчдод зориулсан онлайн үнэлгээний удирдамж](#), [Бичил баталгаажуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх нь](#): Практик зөвлөмж болон Европын холбооноос гаргасан МБС-ын систем дэх [багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан бичил сургалт](#) зэрэг материалууд орно.

Цар тахлын дараах үеийн дунд болон үрт хугацааны хариу арга хэмжээ:

Албан бус боловсрол, насанд хүрэгчдийн сургалтыг үндэсний боловсролын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болгох

- Албан бус боловсрол, насанд хүрэгчдийн сургалтыг боловсролын үндэсний төлөвлөгөө эсвэл МХХТ-ийн боловсролын мастер төлөвлөгөөнд тусгасан байх ёстой. Зөвхөн тодорхой бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд санхүүгийн тусламж үзүүлэх замаар энэхүү дэд салбар нь хямралыг даван туулах тогтолцоонд хүрч урагшлах боломжтой юм. Төрөл бүрийн технологи, шаардлагатай дижитал үр чадварыг зорилтот бүлгүүдэд зориулсан үндэсний төлөвлөгөөнд нэгтгэх боломжтой; үүнд насанд хүрэгчдийн болон олон нийтийн сургалтын төвүүдийг интернетийн холболттой болгох, сургалтын материалыг цахимжуулах, шинээр гарч ирж буй эрэлт хэрэгцээнд зориулан сургалт зохион байгуулах, насанд хүрэгчдийн боловсрол олгогчдын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх зэрэг ажлуудыг сургалтын уян хатан, сонголтот хувилбаруудыг хүлээн зөвшөөрөх болон боловсролын цогц бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх ажил багтана.

Бүх нийтэд тэгш, хүртээмжтэй байдлыг хангах

- Дижитал хуваагдал, дижитал чадварын ялгаа үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс гадна ([ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын зайн сургалтын стратегийн](#) талаарх онцлох сэдвийг үзнэ үү) бичиг үсгийн боловсрол багатай насанд хүрсэн суралцагсдын нээлттэй, зайн сургалтад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Энэ нь ялангуяа цар тахлын дараах нөхцөлд насанд хүрэгчдийн суралцахуйтай ихээхэн хамааралтай юм.
- Бичиг үсгийн боловсрол, үр чадвар багатай [хүмүүсийг дижитал үйл ажиллагаанд хамруулах талаар хийсэн судалгаа](#) нь аливаа дижитал шийдлийг тодорхойлохын өмнө төрөл бүрийн үүрэг, хүргэх суваг, нэвтрэх төхөөрөмж, хэрэглэгчийн интерфэйс сонголтүүд, агуулгын төрөл, дэмжлэг үзүүлэх хувилбар, боломж бололцоо зэргийг анхаарвал зохистой гэдгийг харуулсан.
- ОУХБ, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, НҮБ-ын их сургууль (НҮБ), Гар утасны харилцаа холбооны дэлхийн систем зэрэг байгууллагууд жендэрийн дижитал ялгааг арилгах зорилгоор [ЭКУАЛС](#) (EQUALS) олон талт санаачлагыг 2016 онд эхлүүлсэн. Өнгөрсөн жил ЭКУАЛС-ыг ашиглагчдын эвсэл нь нээлттэй, зайн сургалтын хөтөлбөрийг загварчлахад ашиглаж болох, ашиглахад хялбар хэрэглэх боломжтой [“Интернетийн хүртээмж, хэрэглээн дэх жендэрийн ялгааг арилгах 10 сургамж”](#) сэдэвт баримт бичгийг гаргасан.

Стратегийн түншлэлийг бий болгож, зохицуулалтын механизмыг бэхжүүлэх

- Олон талт төр, хувийн хэвшлийн түншлэлийг судлах шаардлагатай. Орон нутгийн их сургуулиуд насанд хүрэгчдийн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж, онлайн агуулгыг үнэ төлбөргүй хуваалцаж байгаа нь ажиглагдсан.
- Цахилгаан холбооны компаниудтай хамтран боловсрол олгох зорилгоор [интернет холболт](#), сим картаар үнэ төлбөргүй хангасан нь бүх хүмүүсийг онлайн сургалтад хамруулах нэг арга зам юм.

Хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх үйл явцыг бий болгох ёстой.

- Нээлттэй, зайн сургалт зэрэг боловсролын төрөл бүрийн хувилбаруудад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь КОВИД-19 зэрэг хямралыг насанд хүрэгчдийн албан бус суралцахуйг өөрчлөх боломж болгон ашиглах нь чухал юм. Сургалтын хүртээмж, гүйцэтгэлийн чанар, оролцооны түвшин, цаг хугацааны түршид ажиглагдаж буй оролцооны түвшин, сургалтын үр дүн зэрэг мэдээлэлд нэмэлт болгон дадлагажигчид, суралцагчдын дунд тодорхой давтамжтайгаар хийсэн судалгаагаа дамжуулан мэдээлэл цуглуулж болох юм. Ийм мэдээлэл нь ялангуяа цар тахлын дараах сэргэлтийн үед дижитал шийдлүүдийн цаашдын давтамжийг төлөвлөх, өөрчлөхөд чухал ач холбогдолтой юм.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ, үндэсний хариу арга хэмжээ:

Афганистаны Боловсролын яам. 2020 он. Боловсролын төлөвлөгөөний хувилбар. Кабул хот, Боловсролын яам [онлайн]. Холбоос: <https://moe.gov.af/en/strategic-plan-0> [2020/06/21-ны өдөр хандсан].

Бүгд Найрамдах Бенин улсын Засгийн газар. 2020 он. Бенин улсын “КОВИД-19” цар тахлын эсрэг Эв санааны нэгдлийн болон төр, хувийн хэвшлийн санаачлагууд [онлайн] Холбоос: <https://www.gouv.bj/coronavirus/initiatives/> [2020/06/20-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2020а. Боловсрол: Тасалдлын нөхцөл байдлаас үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх үе шатуу шилжих нь. [онлайн] Холбоос: <https://en.unesco.org/covid19/educationresponse> [2020/06/20-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2020b. Онцгой байдлын үеийн боловсрол. [онлайн] Холбоос: <https://en.unesco.org/themes/education-emergencies> [2020/06/21-ны өдөр хандсан].

Дижитал хуваагдлыг шийдвэрлэх нь:

ЮНЕСКО. 2018 он. Ур чадвар, бичиг үсгийн боловсрол багатай хүмүүсийг дижитал үйл ажиллагаанд тэгш хамруулах нь: Нөхцөл байдлын үнэлгээ. Парис, ЮНЕСКО. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000261791.locale=en> [2020/06/21-ны өдөр хандсан].

ЮНЕСКО болон Технологийн салбарт жендэрийн тэнцвэрт байдлыг дэмжихэд чиглэсэн Засгийн газар, байгууллагуудын дэлхийн түншлэл (ЭКУАЛС). 2019 он. “Чаддаг бол ичингүйрэх байсан: Боловсролын дэмжлэгтэйгээр дижитал ур чадварын жендэрийн хуваагдлыг арилгах нь. Парис, ЭКУАЛС. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000367416.locale=en> [2020/06/29-ны өдөр хандсан].

ЮНЕСКО-ийн Насан туршийн боловсролын хүрээлэн (НТБХ). 2016 он. Ялгааг арилгах нь: Насанд хүрэгчдийн дээд боловсролыг дэмжих алсын зайн сургалтын боломжууд. Хамбург, НТБХ. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000243264.locale=en> [2020/06/22-ны өдөр хандсан].

Нээлттэй, зайн сургалтыг ашиглах шилдэг туршлага, найдвар төрүүлж буй тохиолдлууд:

ЮНЕСКО-ийн Насан туршийн боловсролын хүрээлэн (НТБХ). 2016 он. Мэдээлэл харилцаа холбооны технологийн боломжуудыг ашиглах нь: Радио, ТВ, гар утас, таблет, компьютер ашиглан бичиг үсэг, математикийн боловсрол олгох нь. Хамбург, НТБХ. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000243981.locale=en> [2020/06/23-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2014 он. Гар утасны эрин үеийн уншлага: Хөгжиж буй орнуудад гар утасны дэмжлэгтэйгээр суралцах боломжийн талаарх судалгаа. Парис, ЮНЕСКО. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000227436.locale=en> [2020/06/22-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2015 он. Гар утас болон бичиг үсгийн боловсрол: Эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь: Есөн тохиолдлыг харьцуулсан дүн шинжилгээ. Парис, ЮНЕСКО. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000234325.locale=en> [2020/06/25-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2018 он. Суралцахуйн өөр арга зам: Дүрвэгсдийн боловсролыг дэмжихэд гар утасны технологийг ашиглах нь. Парис, ЮНЕСКО. [pdf] Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000261278.locale=en> [2020/06/25-ны өдөр хандсан].

НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар. 2020 он. КОВИД-19-ийн үед боловсролын тасралтгүй байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь: Хямралын үед найдвар төрүүлсэн туршлагууд. Копенхаген, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар. [pdf] Холбоос: <https://www.unhcr.org/5ea7eb134.pdf> [2020/06/22-ны өдөр хандсан].

Нээлттэй, зайн сургалтыг ашиглах шилдэг туршлага, найдвар төрүүлж буй тохиолдлууд:

Сургалтын хамтын нөхөрлөл. 2020 он. КОВИД-19-ийн үед сургуулийн үйл ажиллагааг үргэлжүүлэх нь [онлайн] Холбоос: <https://www.col.org/resources/keeping-doors-learning-open-COVID-19> [2020

оны 6-р сарын 22-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2013 он. Гар утас ашиглан суралцахад зориулсан ЮНЕСКО-ийн удирдамж. Парис, ЮНЕСКО. [pdf] Холбоос: <https://bit.ly/2YOjzRy> [2020 оны 6-р сарын 25-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2018 он. Тэгш хамруулсан дижитал шийдлийг боловсруулж, дижитал ур чадварыг хөгжүүлэх удирдамж. Парис, ЮНЕСКО. [pdf] Холбоос: <https://bit.ly/3dTp59D> [2020 оны 6-р сарын 25-ны өдөр хандсан].

ЮНЕСКО. 2020 он. Зайн сургалтын шийдлүүд [онлайн] Холбоос: <https://en.unesco.org/COVID19/educationresponse/solutions> [2020 оны 6-р сарын 20-ны өдөр хандсан].

ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын онцлох асуудал

ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын онцлох асуудалд КОВИД-19 цар тахлын эсрэг Боловсролын хариу арга хэмжээтэй холбогдох гол сэдвүүдийг хөндөнө. Үүнд сургууль хаагдсантай холбоотой гарсан үр нөлөөг бууруулах хүчин чармайлтын хүрээнд сайн туршлага бүхий баримт, практик зөвлөмж, агуулга тус бүрийн гол эх сурвалж, холбоосыг багтаасан.

Онцлох асуудал нь дараах үндсэн есөн агуулгын хүрээнд хэд хэдэн асуудлыг хамарна. Үүнд: Эрүүл мэнд ба сайн сайхан байдал; Суралцахуй болон багшлахуйн тасралтгүй байдал; Жендэрийн тэгш боломж ба тэгш байдал; Багшлахуй ба суралцахуй; Дээд боловсрол ба Техник мэргэжлийн боловсрол, сургалт; Боловсрол ба соёл; Боловсролын бодлого, төлөвлөлт; Эмзэг бүлгийн хүн ам; Дэлхийн иргэний боловсрол ба Тогтвортой хөгжлийн боловсрол зэрэг орно.

Энэхүү сэдвийг ЮНЕСКО-ийн Насан туршийн суралцахуйн хүрээлэнгээс боловсруулсан болно.

Бидэнтэй хамт багаарай

КОВИД-19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн
Боловсролын салбарын хариу арга хэмжээ



COVID19taskforce@unesco.org



<https://en.unesco.org/covid19/educationresponse>



@UNESCO



@UNESCO